



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 01 сарын 28 өдөр

Улаанбаатар хот

## ДОНОРЫН ТУХАЙ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

#### Нийтлэг үндэслэл

#### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь бусдын эрүүл мэндийг сайжруулах, амь насыг аврахын тулд хүмүүнлэг сэтгэлээр сайн дураараа цус, эд эрхтнээ үнэ төлбөргүй өгөх, амьгүй донорын эд, эрхтэнг шилжүүлэн суулгах зорилгоор авах, цус, цусан бүтээгдэхүүн, эд эрхтэнг эмчилгээний зориулалтаар хэрэглэхээр авах, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, хэрэглэх, экспортлох, импортлох, донорын үйлсийг сурталчлах, түүнд иргэдийг татан оролцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл. Донорын тухай хууль тогтоомж

2.1. Донорын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "хүний эд, эрхтэн" гэж хүний цус, нөхөн үржихүйн эд /өндгөвч, төмсөг, өндгөн эс, сүн, ураг/-ээс бусад эд, эрхтэнг;

3.1.2. "амьд донор" гэж бусдын эрүүл мэндийг сайжруулах, амь насыг аврахад зориулан түргэн нөхөн төлждөг эд /арьс, чөмөг/, эсхүл хос эрхтнийхээ нэгийг өгөгчийг;

3.1.3. "цусны донор" гэж бусдын эрүүл мэндийг сайжруулах, амь насыг аврахад зориулан сайн дураараа цусаа өгөгчийг;

3.1.4. "амьгүй донор" гэж тархины үйл ажиллагаа эргэшгүй алдагдаж, нас барсан нь тогтоогдсоны дараа хэвийн үйл ажиллагаатай байгаа зарим эд, эрхтэнг нь шилжүүлэн суулгах зорилгоор авч болох цогцсыг;

3.1.5. "эд, эрхтний тохироо" гэж донор болон реципиентийн эд, эрхтэн удам зүйн шинжээрээ тохирох зэрэглэлийг;

3.1.6. "реципиент" гэж амь насыг нь аврах, эрүүл мэнд, гоо сайхныг нь сайжруулах зорилгоор донорын цус сэлбүүлэх, эд, эрхтэнг шилжүүлэн суулгуулах зайлшгүй шаардлагатай хүнийг;

3.1.7. "идэвхтэн донор" гэж гурав ба түүнээс дээш удаа цусаа өгөгчийг;

3.1.8. "итгэмжлэгдсэн донор" гэж тогтоосон хугацаанд донорын шалгуур шинжилгээнд урьдчилан хамрагдсан, сумын эмнэлгийн түвшинд яаралтай тусламж үзүүлэх тохиолдолд шууд цусаа өгөгчийг.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **Донор, реципиент, эрүүл мэндийн байгууллагын ажилтанд тавих шаардлага**

#### **4 дүгээр зүйл. Донорт тавих шаардлага**

4.1. Донор нь бусдын эрүүл мэндийг сайжруулах, амь насыг аврахад зориулан цус, эд, эрхтнээ өгөхдөө ашгийн төлөө бус, сайн дурын байх зарчмыг баримтлах бөгөөд донорын үйл ажиллагааг ашиг орлогын эх үүсвэр болгохыг хориглоно.

4.2. Донор болгохоор тулган шаардаж үл болно.

4.3. Донорыг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.

4.4. Цусны донорт дараахь ерөнхий шаардлага тавигдана:

4.4.1. өөрийн эрүүл мэндийн байдал, донорын шаардлагад харшлах гаж зуршлуудыг үнэн зөвөөр мэдэгдэх;

4.4.2. эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон донор сонголтын заавартай танилцаж, зөвшөөрлөө бичгээр өгөх;

4.4.3. идэвхтэн болон итгэмжлэгдсэн донор өөрийн эрүүл мэндэд байнга анхаарал тавьж шаардлагатай үзлэг, шинжилгээнд тогтоосон хугацаанд хамрагдах.

4.4.4. донорын эрүүл мэндэд шаардлагатай үзлэг шинжилгээний төрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

4.5. Донорын эд, эрхтэнг худалдах, худалдан борлуулахаар сурталчлахыг хориглоно. Энэ нь эмнэлгийн мэргэжилтэн хүний эрүүл мэндийг сайжруулах, амь насыг аврах зорилгоор донорын цус,

эд, эрхтэн бэлтгэхийн ач холбогдлыг сурталчлах, тохироо бүхий цус, эд, эрхтэн хайх үйл ажиллагаа явуулахад хамаарахгүй.

## **5 дугаар зүйл. Донор сонгох зарчим**

5.1. Донорт болон донорын цус, эд, эрхтэнд дараахь зорилгоор холбогдох шинжилгээ хийнэ. Үүнд:

5.1.1. цус, эд эрхтнээ өгснөөс донорын эрүүл мэндэд аюул учруулж болох эмгэг өөрчлөлтийг илрүүлэх, гарч болзошгүй хүндрэл, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх;

5.1.2. донорын цус хийлгэсэн болон эд, эрхтэн шилжүүлэн суулгуулсан реципиентийн эрүүл мэндэд аюул учруулж болох эмгэг өөрчлөлтийг илрүүлэх, эд, эрхтний тохироог тогтоох.

5.2. Донорын цус, цусан бүтээгдэхүүнийг эмчилгээний зориулалтаар хэрэглэхэд тохирч байгаа эсэхийг холбогдох шинжилгээгээр тогтооно.

5.3. Донорын эрүүл мэндийн шалгуур, донорын цус, цусан бүтээгдэхүүнийг эмчилгээний зориулалтаар хэрэглэхэд тохирч байгаа эсэхийг тогтоох үзүүлэлт, хориглох заалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

## **6 дугаар зүйл. Донорын эрх**

6.1. Донор нь дараахь эрхийг эдэлнэ:

6.1.1. цус, эд, эрхтнээ өгөх явцдаа өөрийн эрүүл мэнд, амь нас аюулгүй байх эрхээр бүрэн хангагдах;

6.1.2. Хөдөлмөрийн тухай хуулийн 64.1.-д заасны дагуу донорын үүргээ гүйцэтгэх үед дундаж цалин хөлстэй тэнцэх олговор авах.

6.2. Цус, эд, эрхтнээ өгсөн донорын эрүүл мэндэд учирсан хохирол, гарсан хүндрэл цус сэлбүүлэх, эд эрхтэн шилжүүлэх ажилбарын технологийн заавар зөрчсөнөөс үүдсэн нь тогтоогдсон бол тухайн донор нь цус сэлбэсэн, эд, эрхтэнг шилжүүлэн суулгасан буруутай этгээдээр хохирлоо нөхөн төлүүлнэ.

6.3. Донор нь цус, эд, эрхтэн өгөх болон дархлаажуулалт хийлгэхтэй холбоотой хүндрэл учирсан тохиолдолд эмчилгээний төлбөрийг цус сэлбэх, эд эрхтэнг шилжүүлэн суулгах ажилбарыг гүйцэтгэсэн байгууллагаар төлүүлэхээр донорын төрлөөс хамааран гэрээ байгуулах, эсхүл эрүүл мэндийн нэмэлт даатгалд хамрагдаж болно.

## **7 дугаар зүйл. Реципиентэд тавих шаардлага**

7.1. Үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол харгалзахгүйгээр иргэн эрүүл мэндээ сайжруулах, амь насаа аврах, гоо сайхныхаа хэрэгцээг хангах зорилгоор донорын цус сэлбүүлэх, эд, эрхтэн шилжүүлэн суулгуулах ажилбарыг хийлгүүлж болно.

7.2. Донорын эд, эрхтэн шилжүүлэн суулгахдаа 18 насанд хүрсэн реципиент бол өөрийнх нь, харин хүүхэд болон эрхийн бүрэн чадамжгүй иргэн бол эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлийг тус тус бичгээр авсны үндсэн дээр гүйцэтгэнэ.

7.3. Реципиент нь цус сэлбүүлэх, донорын эд, эрхтэн шилжүүлэн суулгуулах ажилбарын дараа амь нас нь аврагдах буюу эрүүл мэнд, гоо сайхан нь сайжрах найдвартай болохыг зохих шалгуурыг баримтлан мэргэжлийн эмч нарын комиссын шийдвэрээр тогтооно. Мэргэжлийн эмч нарын комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

## **8 дугаар зүйл. Эрүүл мэндийн байгууллагын ажилтанд тавих шаардлага**

8.1. Донорын цус сэлбэх, эд, эрхтэн шилжүүлэн суулгах ажилбарыг магадлан итгэмжлэл бүхий эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан эмч гүйцэтгэнэ.

8.2. Цус, цусан бүтээгдэхүүн, шилжүүлэн суулгах эд, эрхтэн нь ашиг олох зорилгоор бэлтгэгдсэнийг холбогдох байгууллагаас нотолсон тохиолдолд тэдгээрийг хэрэглэхийг хориглоно.

8.3. Эд, эрхтэн шилжүүлэн суулгах ажилбар гүйцэтгэхэд оролцсон энэ хуулийн 8.1-д заасан этгээд үзүүлсэн үйлчилгээнийхээ төлбөрөөс давсан төлбөр, урамшуулал авахыг хориглоно.

8.4. Эмч, эрүүл мэндийн ажилтан нь донор болон реципиентийн эрүүл мэндийн нууцыг хадгалж, донорын шинжилгээний явцад илэрсэн эмгэг өөрчлөлтийг зөвхөн шинжлүүлэгчид мэдээлнэ.

8.5. Реципиентэд тавих нөхцөл, шаардлага хангасан хүмүүсийг олон улсын шалгуур үзүүлэлтийн дагуу хүлээх жагсаалтанд авч, харилцан мэдээлэх ажлыг эд, эрхтэн шилжүүлэн суулгах тусгай эрх бүхий эмч, эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэн хариуцна.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

### **Донороос цус, эд, эрхтэн авах, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах**

#### **9 дүгээр зүйл. Эд, эрхтэн шилжүүлэн суулгахад тавих үндсэн шаардлага**

9.1. Донороос цус, эд, эрхтэн авах, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах ажлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаас зөвшөөрөл авсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагын ажилтан шаардлага хангасан эмнэлгийн нөхцөлд гүйцэтгэнэ.

9.2. Шилжүүлэн суулгах эд эрхтэнг аль болох амьгүй донороос авбал зохино. Амьд донороос эрхтнийг авахдаа ихрүүд, ах, дүү, ураг, төрлийн бусад эрүүл хүнийг сонгоно.

9.3. Хүүхдээс ясны хэм, чөмөг, хүйн цуснаас бусад эд, эрхтэнг шилжүүлэн суулгах зориулалтаар авахыг хориглоно.

#### **10 дугаар зүйл. Амьд донороос эд, эрхтэн авах**

10.1. Сэтгэцийн хувьд эрүүл, 18 насанд хүрсэн, шаардлагатай шинжилгээ хийлгэсэн, эд, эрхтнээ өгөх зөвшөөрлөө бичгээр өгсөн донорын эрүүл мэндэд аюул учруулахгүйгээр эмнэлгийн нөхцөлд түүний эд, эрхтэнг авна.

10.2. Хүүхдээс ясны хэм, чөмөг, хүйн цус авахдаа 14 хүртэлх настай бол эцэг, эх болон асран хамгаалагчийн, 14-өөс дээш настай бол өөрийн болон эцэг, эх. харгалзан дэмжигчийн бичгээр гаргасан зөвшөөрлийг тус тус авна.

## **11 дүгээр зүйл. Амьгүй донороос эд, эрхтэн авах**

11.1. Амьгүй донор болохыг тархины үхлийн эмнэлзүйн шалгуурыг баримтлан мэргэжлийн эмч нарын комисс тогтооно.

11.2. Тархины үхлийн эмнэлзүйн шалгуурыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

11.3. Амьгүй донороос эд, эрхтэн авахдаа нас барагчийн өөрийн гэрээслэл, эсхүл түүний төрөл, садангийн зөвшөөрлийг бичгээр авах буюу шаардлагатай бол хуулийн байгууллагын зөвшөөрлийг үндэслэнэ.

11.4. Амьгүй донороос эд, эрхтэн авахдаа зарим эрхтэн, эсхүл эрхтнүүдийн ажиллагааг зохиомлоор хэвийн байлгаж болно.

11.5. Донорын эд, эрхтэн шилжүүлэн суулгах ажилбарт оролцож байгаа буюу реципиентийг эмчилж байгаа эмч нь энэ хуулийн 11.1-д заасан мэргэжлийн эмч нарын комиссын бүрэлдэхүүнд орохыг хориглоно.

11.6. Донор, реципиент нарын эд, эрхтний тохироог Эрүүл мэндийн тухай хуулийн 18.2-т заасны дагуу тусгай зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллагад тодорхойлно.

11.7. Амьгүй донороос эд, эрхтэн авсны дараа донорын гадаад байдлыг анхны янзанд нь оруулахыг эд, эрхтэн авсан эрүүл мэндийн байгууллага хариуцна.

## **12 дугаар зүйл. Донорын цус, эд, эрхтэнг эмчилгээний зориулалтаар авах, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах**

12.1. Донороос цус, эд, эрхтэн авах, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах нөхцөл, технологийн болон шаардлага хангахгүй цус, цусан бүтээгдэхүүн, эд эрхтэнг устгах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно. Энэ ажлыг Эрүүл мэндийн тухай хуулийн 18.2-т заасны дагуу холбогдох зөвшөөрөл авсан эрүүл мэндийн байгууллага эрхэлнэ.

12.2. Тусгай зөвшөөрөл авсан эрүүл мэндийн байгууллага нь донорын цус, цусан бүтээгдэхүүн, эд, эрхтэнг авч зохих журмын дагуу хадгалах бөгөөд энэ хуулийн 8.1-д заасан этгээдэд захиалгаар нийлүүлнэ.

## **13 дугаар зүйл. Донорын цус, цусан бүтээгдэхүүн, эд, эрхтэнг улсын хилээр нэвтрүүлэх**

13.1. Арилжааны зориулалтаар, эсхүл баталгаажаагүй цус, цусан бүтээгдэхүүн, эд, эрхтэн экспортолж, импортлохыг хориглоно.

13.2. Эд, эрхтэн бэлтгэж хадгалдаг олон улсын байгууллагатай байгуулсан Монгол Улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу зөвхөн эмчилгээний зориулалтаар баталгаажсан эд, эрхтэн экспортолж, импортолж болно.

13.3. Донорын цус, цусан бүтээгдэхүүн, эд, эрхтэнг улсын хилээр нэвтрүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь холбогдох бусад байгууллагатай хамтран тогтооно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **Донорын эгнээг өргөжүүлэх**

#### **14 дүгээр зүйл. Донорын үйлсийг сурталчлах**

14.1. Донорын эгнээг өргөжүүлэхийн тулд донорын хөдөлгөөнийг сурталчлах ажлыг Монголын улаан загалмай нийгэмлэг нь төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран гүйцэтгэнэ.

14.2. Бусдын эрүүл мэндийг сайжруулах, амь насыг аврахын төлөө иргэд сайн дураараа цус, эд, эрхтнээ өгөхийн ач холбогдол, донорын үйлсийг сурталчлах мэдээлэл сурталчилгааны ажлын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

#### **15 дугаар зүйл. Донорын үйлсэд идэвхтэй оролцсон иргэн, байгууллагыг урамшуулах**

15.1. Хүмүүнлэг, энэрэнгүй сэтгэлээр донорын үйлсэд идэвхтэй оролцсон донорт эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, халамж, хөнгөлөлтийн нэмэлт үйлчилгээ үзүүлэх журмыг Засгийн газар тогтооно.

15.2. Донорыг урамшуулах, алдагдсан эрч хүчийг нөхөн сэргээх үүднээс байгууллага, хамт олон, хувь хүн эд материал, санхүүгийн болон сэтгэл зүйн тусламж үзүүлж болно.

## **ТАВДУГААР БҮЛЭГ**

### **Бусад зүйл**

#### **16 дугаар зүйл. Санхүүжилт**

16.1. Донороос цус, цусан бүтээгдэхүүн, эд, эрхтэнг эмчилгээний зориулалтаар авах, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, тохирсон донор хайх үйл ажиллагааны зардлыг төр хариуцна.

16.2. Донорын цус, цусан бүтээгдэхүүний боловсруулалт болон аюулгүйн баталгааг хангах арга хэмжээний зардал, эд, эрхтэн шилжүүлэн суулгах ажилбарын үйлчилгээний үнийн жишгийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох бусад албадтай хамтран тогтооно.

#### **17 дугаар зүйл. Донорын үйлчилгээний хяналт**

17.1. Донороос цус, эд, эрхтэнг авах, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгахтай холбогдсон хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан журмын хэрэгжилтэд эрүүл мэндийн мэргэжлийн хяналтын алба, тэдгээрийн байцаагч нар хяналт тавина.

#### **18 дугаар зүйл. Донорын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

18.1. Донорын тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдийн дараахь үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжгүй бол хууль тогтоомжоор тусгайлан эрх олгогдсон улсын байцаагч, шүүгч зөрчлийн шинж байдлыг харгалзан дор дурдсан захиргааны шийтгэлийг ногдуулна:

18.1.1. энэ хуулийн 8.4-ийг зөрчсөн бол 40000-50000 төгрөгөөр торгох;

18.1.2. энэ хуулийн 4.1; 4.4; 10.1; 10.2-ыг зөрчсөн бол иргэнийг 20000-30000, албан тушаалтныг 30000-40000 төгрөгөөр торгох;

18.1.3. энэ хуулийн 4.5; 8.1; 13.1-ийг зөрчсөн бол экспортолж болон импортолж байгаа цус, цусан бүтээгдэхүүн, эд, эрхтэнг устгаж, зөрчил гаргасан иргэнийг 20000-30000, албан тушаалтныг 30000-50000, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох;

18.1.4. энэ хуулийн 6.2; 7.2; 7.3; 9.1; 11.3; 11.5; 11.6; 12.1; 16.2-ыг зөрчсөн албан тушаалтныг 30000-50000, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох;

18.1.5. энэ хуулийн 4.2; 4.3; 8.2; 8.3-ыг зөрчсөн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, зөрчил гаргасан иргэнийг 20000-30000, албан тушаалтныг 30000-50000, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох.

18.2. Иргэний эрүүл мэндэд учруулсан гэм хорын хохирлыг Иргэний хууль, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн холбогдох заалтын дагуу гэм буруутай этгээд нөхөн төлнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**